



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 192

Улаанбаатар хот

### “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан цогц арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг холбогдох талуудын оролцоотой хамтран боловсруулж, батлан хэрэгжүүлэх, төрийн өмчийн бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын багш нарыг компьютержуулах, цахим сургалт зохион байгуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг үе шаттай авч, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг тооцож, жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд даалгасугай.

3. “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ”-г хэрэгжүүлж, багш мэргэжлийн нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд салбараас хамаарах шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

**“БАГШИЙН ГУРВАН ТУЛГУУРТ БОДЛОГО”  
ЦОГЦ АРГА ХЭМЖЭЭ**

**Нэг.Танилцуулга**

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д боловсролын салбарын хүний нөөцийн цогц бодлого хэрэгжүүлж, чадварт суурилсан зарчмаар албан тушаал, мэргэжлийн хөгжлөө тодорхойлох боломжтой тогтолцоог бий болгох, сургалтын байгууллагыг мэргэжлийн багшаар хангах, багш бэлтгэдэг сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг багшийн чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр заасан.

Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар баталсан Боловсролын ерөнхий хуульд багшийг магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэх, хувилбарт сургалтаар бэлтгэх, багшид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлэх, мэргэжлийн хөгжил болон гүйцэтгэлд суурилсан нэмэлт урамшууллын талаар шинэлэг зохицуулалтыг тусгасан.

Мөн Багшийн хөгжлийг дэмжих тухай хуульд сургалтын байгууллагад суурилсан багшийн хөгжлийн төвүүдийг байгуулж, багш ажлын байрандаа хөгжих бүх боломжийг олгох талаар тодорхой заасан байдаг нь энэ арга хэмжээний эрх зүйн үндэслэл болно.

2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монголын багш нарын VIII их хурлын үеэр багш нарын өмнө тулгарч байгаа тулгамдсан асуудлын дотор багшийн хангалт, шилжилт хөдөлгөөн, багшийн хөгжил, ёс зүй, нэр хүнд, багшийн нийгмийн баталгаа, цалин хөлстэй холбоотой асуудлыг хэлэлцэж, тодорхой арга хэмжээ авах чиглэлээр их хурлын шийдвэрт тусгасан нь багшийн хүртээмж, чанарыг сайжруулах арга хэмжээний үндэслэл болж байна.

Боловсролын бүх түвшний сургалтын байгууллагад тулгамдаж байгаа нийтлэг асуудал нь багшийн хүртээмж байна.

Үндэсний статистикийн хороо, Боловсрол, шинжлэх ухааны яамнаас 2021 онд хийсэн судалгаагаар цаашид хүн амын тоо өсөх төлөвтэй байгаа бөгөөд 2030 он гэхэд дунд, ахлах сургуулийн насны сурагчдын тоо 2018 онтой харьцуулбал 71 хувиар өсөх төлөвтэй байна. 2030 он гэхэд ерөнхий боловсролын сургуульд 53,000 багш шаардлагатай байгаагаас хамгийн их эрэлт хэрэгцээтэй нь бага ангийн, монгол хэл, уран зохиол, үндэсний бичгийн, дүрслэх урлаг, зураг зүй, технологи, математикийн болон англи хэлний багш нар байх төлөвтэй байна.

Мөн хүүхдийн тооны өсөлттэй холбоотой 2030 он гэхэд сургуулийн өмнөх боловсролд 18,808 багш, мэргэжлийн болон техникийн боловсролд шинээр 2,352 багшийн хэрэгцээ үүснэ.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас зохион байгуулсан суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын "PISA-2022" үнэлгээний Монгол Улсын үр дүнгээс харахад суурь боловсрол эзэмшсэн сурагчдын 38 хувь нь багшлах боловсон хүчний дутагдалтай байдаг сургуульд сурч байгаа нь сургуулийн захирлын асуулгаар тогтоогдсон бөгөөд эдгээр сургуулийн ихэнх нь хөдөө орон нутагт байна. Энэ нь сумын төвд суралцаж байгаа хүүхэд аймгийн төвийн үе тэнгийн хүүхдээс 1 жилээр, аймгийн төвийн хүүхэд нийслэлийн хүүхдээс 1.5-1.8 жилийн сурлагын хоцрогдол үүсэх хүчин зүйлүүдийн нэг болж байна.

Боловсролын их өгөгдөлд суурилсан дата аналитикийн шинжилгээгээр энэ хичээлийн жилд багшийн 3,245 сул орон тоо буюу нийтдээ 9.5 хувийн дутагдал байгааг харуулж байгаа бөгөөд бага анги, англи хэл, математик, монгол хэл, уран зохиол болон физикийн багш хамгийн их дутагдалтай байна.

Багшийн хомсдол, дутагдлаас гадна багшийн шилжилт хөдөлгөөн, ажлаас гаралт багагүй байна.

2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар багш нарын ажлаас гаралт дунджаар 9.8 хувьтай байгаа бөгөөд 5 хүртэл жил ажиллаж байгаа багш нарын ажлаас гаралт 46.5 хувь байгаа нь шинэ, залуу багш нар байна.

Багш нарын VIII их хурлын үеэр оролцогч төлөөлөгчдийн зүгээс залуу багш нарын ажлаас гаралт болон шилжилт хөдөлгөөн нь ажлын ачаалал, эцэг эх, асран хамгаалагчийн ёс зүйгүй үйлдэл, дарамт шахалт, сургуулийн удирдлагын мэргэжлийн бус байдал зэргээс голлон шалтгаалж байгааг онцлон тэмдэглэсэн байна.

2023 оны IV улирлын байдлаар боловсролын салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 1,882.4 төгрөг байсан нь улсын дундаж болох 2,235.4 төгрөгөөс доогуур байгаа нь багшийн ажлаас гаралт, шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлж байна.

Багшийн хүртээмжээс гадна багшийн чанар боловсролын суурь асуудлуудын нэг болж байна.

Багшийн чанарыг тодорхойлох нэг хэмжүүр нь багшийн гүйцэтгэлийн үнэлгээ юм. Цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 2022 онд 87.6 хувь байсан бол 2023 онд 90.11 хувь болж, ерөнхий боловсролын сургуулийн багшийн гүйцэтгэлийн ерөнхий үр дүн 2022 онд 72.5 хувь байсан бол 2023 онд 75.7 хувийн үр дүнтэй байна.

"PISA-2022" Монгол Улсын үнэлгээний дүнд үндэслэн ЭЗХАХБ-аас өгсөн бодлогын зөвлөмжид Монгол Улсад багш мэргэжлийн хөгжлийн асуудлыг бодлогын тэргүүлэх чиглэлийн нэг болгон дэвшүүлж байгааг тэмдэглээд, багш нар таван жил тутамд албан ёсны сургалтад хамрагдах үүрэгтэйгээс гадна хэрэгцээндээ тулгуурлан сонгон хамрагдах сургалт, сургуулийн түвшний мэргэжлийн хамт олны үйл ажиллагаанд нэгдэн хөгжих боломжтойг онцолсон.

Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлийн дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/07 дугаар тушаалаар баталсан "Чадварлаг багш" (2021-2024) арга хэмжээний хэрэгжилт 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар 90 орчим хувьтай байгаа хэдий ч цаашид багш бэлтгэх сургалтыг чанаржуулах зорилтын хүрээнд багш бэлтгэх

сургалтын хөтөлбөр, түүний чанар, үнэлгээ, багш бэлтгэх болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх асуудал тулгамдсан хэвээр байна.

Иймд Монгол Улсын Засгийн газраас багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах зорилгоор гурван тулгуурт бодлогыг хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ бодлогын хүрээнд багш мэргэжлээр суралцах оюутны сургалтын төлбөрийг энэ хичээлийн жилээс 2030 он хүртэл төр 100 хувь, багш нар дотооддоо магистрт суралцах бол сургалтын төлбөрийг төр 100 хувь хариуцахаар боллоо. Үүний үр дүнд энэ хичээлийн жилд багш мэргэжлээр суралцаж байгаа 4,923 оюутанд нийт 14.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Цаашид Монгол Улсын иргэн бүрд чанартай, хүртээмжтэй, тэгш хамруулсан боловсрол эзэмших боломжийг бүрдүүлэх суурь нөхцөл болсон багшийн чанар, хүртээмжийн асуудлыг шийдвэрлэхийн тулд багшийн чанар, хүртээмжийг сайжруулах “Багшийн гурван тулгуурт бодлого” цогц арга хэмжээ (цаашид “арга хэмжээ” гэх)-г хэрэгжүүлэх шаардлага үүсээд байна.

### Хоёр.Зорилго, баримтлах зарчим, хугацаа

2.1.“Багшийн гурван тулгуурт бодлого”-ын зорилго нь сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд оршино.

2.2.Цогц арга хэмжээг хэрэгжүүлэхэд Боловсролын ерөнхий хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтална.

### Гурав.Зорилт

3.1.Багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.1.1.шинэ багшийг ажлын байрны чиг үүрэгт дадлагажуулах, сургалтын орчин нөхцөлд дасан зохицоход дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

3.1.2.багшийн ажлын ачааллыг бууруулж, цагийн нормыг зохистой тогтоох;

3.1.3.бага анги, англи хэл, математик, монгол хэл, уран зохиол, технологи зэрэг судлагдахууны багшийг хувилбарт сургалтаар нэмж бэлтгэх, хөрвөх боломжийг олгох;

3.1.4.багш мэргэжил эзэмшсэн боловч багшийн ажил эрхлээгүй иргэнийг багшаар ажиллах боломжийг бий болгох, мэргэшүүлэх сургалтад хамруулах;

3.1.5.багшийн нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр холбогдох хууль, эрх зүйн орчныг тодорхой болгох;

3.1.6.эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс багш, ажилтанд үзүүлж буй дарамт шахалт, ёс зүйгүй үйлдэлд хариуцлага хүлээлгэх чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.7.багшийн нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтэд нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулах;

3.1.8.багшийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны өртөг, хүүхдийн тооноос хамаарсан ачааллыг тооцож, цалин хөлсний бүтцэд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;

3.1.9.багш мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх;

3.1.10.багш мэргэжлийн хүний нөөцийн хүйсийн тэнцвэрт байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

3.1.11.нэг багшид ногдох суралцагчийн тоог бууруулж, улсын дунджийг 20 суралцагчид хүргэх;

3.1.12.багшийн ажиллах орчин нөхцөлийн стандарт батлуулж, мөрдөх.

3.2.Багшийн чанарыг сайжруулах чиглэлээр дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

3.2.1.багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын зохион байгуулалт, төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэх, багшлах хүний нөөцийн чадавх, орчин, дэд бүтцийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх;

3.2.2.багшаар анхны жилдээ ажиллаж байгаа багшийн стандартыг тогтоож, багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөр, хувилбарт сургалтын хөтөлбөрт тусгах;

3.2.3.ажлын байранд багшийг чадавхжуулах мэргэжлийн тасралтгүй хөгжлийн тогтолцоог шинэчилж, багшийн карьерын хөгжил, мэргэжлийн чадамжийн хөгжлийг дэмжсэн сургалт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

3.2.4.багшийн мэргэжлийн стандартыг тогтоож, мэргэшлийн зэрэг, мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагаатай нийцүүлэх, цахимжуулах;

3.2.5.багш ажлын байрандаа тасралтгүй хөгжихөд дэмжих, ачааллыг бууруулах чиглэлээр цахим контент, системийг нэвтрүүлэх, багш бүрийг виртуал туслахтай болгох;

3.2.6.багшийн сайн туршлага, цахим контент, сан, судалгааны үр дүн, инновацыг үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх, сургалт, үйл ажиллагаанд нэвтрүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, дэмжлэг үзүүлэх;

3.2.7.ижил түвшний боловсролын сургалтын байгууллагын багш нарыг багш солилцоо, зуны сургалт, гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалтад хамруулах төсөл, хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжүүлэх;

3.2.8.багш бэлтгэх хөтөлбөрийн олон улсын стандартын ангилал (ISCED-T)-ыг нэвтрүүлэх.

## Дөрөв.Удирдлага, зохион байгуулалт

4.1.Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багшийн чанар, хүртээмжийг арга хэмжээний зорилт тус бүрээр хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулна.

4.2.Цогц арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага удирдлагаар хангаж, боловсролын мэргэжлийн байгууллага, бүх түвшний боловсролын сургалтын байгууллага, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-д заасан нэгж, нэгжийн удирдлага, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг оролцогч талууд жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж, хамтран ажиллана.

### Тав.Арга хэмжээний санхүүжилт

5.1.Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1.улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2.гадаад, дотоодын төсөл, хөтөлбөр;

5.1.3.байгууллагын өөрийн хөрөнгө;

5.1.4.хуулиар хориглоогүй бусад.

5.2.Арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгана.

### Зургаа.Хүрэх үр дүн

6.1.Арга хэмжээг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна:

6.1.1.бүх түвшний боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн багшийн хангалт 100 хувьд хүрсэн байна;

6.1.2.багш бэлтгэдэг дээд боловсролын сургалтын байгууллагын гарааны багшийн стандартыг хангасан төгсөгчийн эзлэх хувь 70-аас доошгүй хувьтай байна;

6.1.3.багшийн гүйцэтгэлийн үнэлгээний улсын дундаж 10-аас доошгүй хувиар нэмэгдсэн байна;

6.1.4.багшийн нийгмийн баталгаа, цалин хөлсний талаарх сэтгэл ханамжийн түвшинд жил бүр ахиц гарсан байна;

6.1.5.сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн багшийн мэргэжлийн мэдлэг, ур чадварын үнэлгээний үр дүнд ахиц гарсан байна;

6.1.6.багшийн цалин хөлсний дундаж хэмжээ нь улсын дундаж хэмжээнд хүрсэн байна;

6.1.7.нэг багшид ногдох суралцагчийн улсын дундаж 20-д хүрсэн байна.

---o0o---